

**"Шэлжи мэлон" хэмээх зохиолын С.Шагжийн
орчуулгын тухай**

Д. Бүрнээ
(МУИС)

"Монгол үсгийн дүрмийн толь бичиг", "Эрэхүй хялбар болгон зохиосон үгийн тайлбар чандманийн эрх" хэмээх алдарт толь бичиг болон "Монгол бичиг сурах дөт зам" хэмээх сурах бичиг зэргийг зохиосон эрдэмтэн С. Шагж гуай (1886-1937) одоогийн Булган аймгийн Тэшиг Хангал сумын нутагт малчин ардын гэр бүлд 1886 онд төржээ. Тэрээр Дайчин вангийн хүрээ, Амарбаясгалант хийд, Гандан хийдэд шавилан сууж, шашны гүн ухаан, төвд хэл бичигт нэвтэрч гавжийн зэрэгт хүрсэн бөгөөд 1923 онд шинэ тулгар байгуулагдсан судар бичгийн хүрээлэнд орж, төвд хэлний орчуулагчаар ажиллаж байжээ. С. Шагж гуай нэрт толь зүйч, хэл шинжлэлтэн, орчуулагч байсан бөгөөд тэрээр төвд хэлнээс Их Хүрээний хамба Агванхайдавын "Хонь, ямаа, үхэр гурвын яриа", Зая бандид Лувсанпэрэнлэйн зохиосон "Өндөр гэгээний намтар" зэргийг орчуулж, эрдэмтэн Бат-Очирын хамт Данжурын гарчигийг орчуулан төвд монголоор сийрүүлэн бичжээ. Төвд хэлнээс орчуулсан түүний томхон зохиолын тоонд "Тогтсон таалал бүхний уг хийгээд таалах ёсыг номлосон сайн номлол болорын толь" хэмээх зохиол орох бөгөөд энэхүү орчуулгын гар бичмэл эх болон орчуулгын үгсийн сан, хэл найруулгын тухай товч өгүүлбэр.

Нэг. Орчуулгын гар бичмэл эхийн тухай

С. Шагж гуай төвдийн эрдэмтэн Туган Лувсанчойжиням буюу Дармабазар (1737-1802)-ын 1802 онд бичиж дуусгасан "Тогтсон таалал бүхний уг хийгээд таалах ёсыг номлосон сайн номлол болорын толь" (төвд хэлээр Grub mtha' thams cad kyi 'byung khuṅg dang 'dod tshul ston pa legs bshad shel kyi me long), товч нэрээр "Туганы тогтсон таалал" (Туган дунтаа), "Шэлжи мэлон" (Болорын толь) хэмээн алдаршсан түүхэн шастирыг 1924 онд орчуулжээ. Уг орчуулгын төгсгөлд "тогтсон таалал бүхний уг хийгээд таалах ёсыг номлосон сайн номлол болрын толь хэмээх үүнийг монгол ардын намын судар бичгийн хүрээлэнгийн төвд хэлний орчуулагчийн хүнд нэрийг хүлээсэн хуврагийн дүрст Шагж хэмээх бээр арван тавдугаар машинд гарсан модон хулгана жилийн мэргэшир сарын (арван нэгдүгээр сар Д. Б.) арван тавнаа төгссөн орчуулвай. Эс оносон ба буруу оносны эрхээр буруу орчуулсан гэм буй аваас эрдэмтэн мэргэд бээр ариутган өршөөх ажаамуу. Үүнийг хичээн орчуулсны буянаар эгээрэн үзэгчид утгыг нь онож, энэ насны хурьцал шуналыг тэвчээд, эрхэн үзлийг түргэнээ олох болтугай" хэмээн бичсэнээс үзвэл уг орчуулгыг эрдэмтэн Шагж гуай хийсэн нь тодорхой байна. Шагж гуайн орчуулсан "Шэлжи мэлон" хэмээх зохиол 12 бөлөгтэй. Үүнд энэтхэг, төвд, хятад, монгол, хотон зэрэг оронд бурханы шашин эрт ба хожуу үед дэлгэрсэн түүх, төвдийн шашны нинмава, гаадамба, гаажүдба, шижэдба, сажава, жонанба, бон зэрэг шашны урсгал чиглэлийн түүх, гүн ухааны үзэл онолын тухай дэлгэрэнгүй өгүүлжээ. Энэ зохиолыг европ дахинаа 19-р зууны үеэс мэдэх болсон бөгөөд эрдэмтэн С. Ч. Дас¹ бонгийн шашин, хятадын күнз, даосын

¹ S. Ch. Das, *Contribution on the Religion, History etc. of Tibet*, Journal of Asiatic Society of Bengal. Calcutta, 1881, 1883.

шашин хийгээд Монгол болон төвдөд бурханы шашин дэлгэрсэн тухай хэсгийг төвд хэлнээс англи хэлнээ, А. Чаттопадхьяа² гаадамбын тогтсон тааллыг англи хэлнээ, Х. Хофман³ бонгийн тогтсон таалалыг герман хэлнээ, Д. Рюег⁴ жонанбын тогтсон тааллыг англи хэлнээ, М.Т атикава⁵ сажаба хийгээд гажүдбийн тогтсон тааллыг япон хэлнээ, Р. Н. Крапивина⁶ сажавын тогтсон тааллыг орос хэлнээ тус тус орчуулжээ. Харин бүрэн орчуулгыг монголын эрдэмтэн С. Шагж гуай хийсэн нь эдүгээ УТНС-гар бичмэл номын хөмрөгт хадгалагдаж байна. Шагж гуайн бүрэн орчуулга байдаг тухай эрдэмтэн судлаачдын бичиж тэмдэглэсэн зүйл байх боловч түүний орчуулгын олон эхийн онцлогийн тухай тусгайлан бичсэн зүйл байхгүй байна. Эрдэмтэн Шагж гуайн "Шэлжи мэлон" хэмээх зохиолын орчуулга бүхий гурван зүйлийн эх УТНС-д хадгалагдаж байна.

Эдгээр нь:

1. Дөрвөн дэвтрээр ноороглогсон эх
2. Хянаж засан 12 дэвтэрт хуулбарласан эх
3. Дахин хянан засаж, хоёр дэвтэрт хуулбарласан сүүлчийн эх гэсэн гурван зүйлийн эх байна. Энэхүү хоёр дэвтэрийн эхний дэвтэр 412, хоёрдугаар дэвтэр 491 хуудастай.

Эхний 4 дэвтэр ноорогийг муутуу цаасан дээр хар бэхээр 11 мөрөөр бичсэн бөгөөд уг эх нь үндсэндээ энэтхэг, төвдийн тогтсон таалал болон төвдийн шашны гаадамба хийгээд гаажүдбийн тогтсон тааллын орчуулга байна. Энэ ноорогоо монгол бичгээр таталж бичсэнээс гадна үг үсгийн засварыг нэлээд хийжээ. Тухайлбал үг хэллэг нэмж оруулсан, буруу бичсэнийг баллаж дарсан буюу дугуйлсан, дарсан үгийн хажууд сонгосон хувилбарыг тэмдэглэсэн байна. Оноосон нэрийг хоёр янзаар бичжээ. 1-рт монгол бичгээр галиглаж хажууд нь төвдөөр бичиж тэмдэглэсэн, 2-рт дараа нь нөхөж бичихээр бодсон бололтой сул зай орхиж, зөвхөн төвдөөр бичсэн байна. Оруулбар үгсийг ажиглабал хоршиж холбох үүднээс үг нэмсэн байхаас гадна орхигдсон үг хэллэгийг нэмжээ. Дарж баллаад нэмж бичсэн үгийг ажиглабал ихэнхидээ монгол бичгийн хэлэнд ойртуулж хийсэн засвар байна. Тухайлбал:

Анх бичсэн нь	Зассан нь
удахын цагт	өнө болсон
үз	үзтүгэй
нэрийдэв	нэрийдсэн амуй
нэг	нэжгээд
хүргэх	сайтар хөтлөх
цөм	бүгд
авчирсан	аван ирсэн
үүнд	үүнээ
хашраах	сөхөөх
байсан	агсан
алдаршив	алдаршсан бөлгөө

Орчуулгын эхний ноорог дэвтэр бол Шагж гуайн үг хэллэгийг оновчтой зөв сонгох үүднээс үгийн сангийн эрэл хайгуул хэрхэн хийж байсан, хэл найруулгыг хэрхэн тунгаан боловсруулж байсныг тодорхой харуулах баримт болохын хувьд сонирхолтой байна.

² A. Chattopadhyaya, *Atisha and Tibet*. Calcutta, 1967.

³ H. Hoffman, *Quellen zur Geschichte der tibetischen Bon-Religion*. Wiesbaden, 1950.

⁴ D. S. Ruegg, *The Jonan-pas. A school of Buddhist Ontologists according to the Grub-mtha Sel gyi me-long*, Journal of the American Oriental Society. Baltimore, Maryland, 1963.-No1. - Vol.83.

⁵ Tukan, *Issaishugi Sakya-ha no sho* (The Sa-skya-pa Chapter of the Grub-mtha-shel-gyi-me-long by Thu'u-bkwan) Trans.from the Tibetan by M. Tachikawa, *Studia Tibetica*. Tokyo, 1974.-Vol.1, No3.

⁶ *Туган Лопсан-Чойкы-Ньима*, Хрустальное зеркало философских систем Глава Сакьяпа, перевод с тибетского, предисловие, введение и комментарий Р. Н. Крапивиной, Дацан Гунзэйчойнэй Санкт-Петербург, 1995.

12 дэвтэр бүхий сийрүүлэгийн тухайд өмнөх нооргоос ялгаатай нь хулсан үзгээр 11 мөрөөр тогтуун сайхан бичсэн эх юм. Энэ сийрүүлэгт үг үсгийг зассан, дарж балласан зүйл харьцангуй цөөн бөгөөд хийсэн засварыг үзвэл зөв бичих дүрмийн дагуу үг үсэг, хэл найруулгыг засаж өөрчилсөн зүйл ажиглагдаж байна. Арван хоёр дэвтэрийг нэгтгэж, хоёр дэвтэрт бичсэн эх бол эцсийн сийрүүлэг бөгөөд энэ нь арван хоёр мөрөөр муутуу цаасан дээр хар бэхээр маш хичээнгүй сайхан бичсэн эх байна. Энэ эхийг өмнөх сийрүүлэг болон төвд эхтэй харьцуулбал ганц нэг өгүүлбэр орхиж хуулсан хийгээд ганц нэг үгийг буруу хуулсан зүйл тааралдаж байна. Өөрөөр хэлбэл эхний сийрүүлэгт зөв бичсэнийг сүүлчийн хуулгад эндүү бичсэн гэсэн үг юм. Тухайлбал "ядам бурханы нүүрийг үзсэн" гэснийг сүүлчийн хуулгад "ядам бурханы нууцыг үзсэн" гэж ташаарч хуулсан буюу "гэцэл, гэлэн нүгүүдэд хоёр... суртгаалыг цээжлүүлж" гэхийг "гэцэл, гэлэн нүгүүдэд хоёр... суртгаалыг цээрлүүлж" гэж эндүүрч хуулсан, зөв бичих дүрмийн дагуу зөв бичсэн үгсийг буруу хуулсан ч мэр сэр тааралдаж байна. Тухайлбал эгшигээр төгссөн нэр үгэнд үйлдэгчийн тийн ялгалын "baḡ", "beḡ" нөхцөлийг залгах ёстой бол "iyaḡ", "iyeḡ"-ийг бичсэн буюу гийгүүлэгчээр төгссөн үгэнд "baḡ", "beḡ"-ийг залгасан ч тааралдаж байна.

"Шэлжи мэлон" хэмээх зохиол төвдийн Гонлүн, Дэргэ болон монголын Нийслэл Хүрээний Гандан хийдийн Дашчоймбол дацанд тус тус бартай бөгөөд С.Шагж гуай 12 бөлөг бүрийг тус тусд нь дугаарласан Гонлүн хийдэд бартай судрыг барьж орчуулжээ. Шагж гуай бөлөг тус бүрийн орчуулгыг тусгай дэвтэрт товхиж хийсэн хийгээд Гонлүн хийдийн барын үг үсгийн алдаа Шагж гуайн орчуулгад хэвээр бууснаас үүнийг бас мэдэж болох байна. Тухайлбал Монгол оронд ном дэлгэрсэн тухай өгүүлсэн бөлөгт Сажийн ёсны лам Сажа бандид Гунгаажалцанг монгол газраас элч ирж урин залах тухай "хэрээ малгайт ба гахайн хоншоорт гутал өмссөн хязгаар газрын хүн залахаар" ирнэ хэмээх өгүүлбэр Шагж гуайн орчуулгад бий. Шагж гуай Гонлүн барын төвд сударт "khwa zhwa" гэж бичсэн байгаа тул "хэрээ малгай" гэж орчуулжээ. Гэтэл Дэргэ барын сударт мөнхүү үг "khwa zhwa" бус харин "khra zhwa" гэж байгаа бөгөөд Шагж гуай "харцага малгай" бус харин "хэрээ малгай" гэж орчуулсан нь Гонлүн барын судрыг барьж орчуулсантай холбоотой. Дэргэ болон Гонлүн хийдийн хоёр барын судрыг тулгаж үзвэл оноосон нэр дээр зөрөө их тааралдаж байна. Үүнийг дараах хүснэгтээс үзнэ үү.

Дэргэ барын судар	Гонлүн барын судар	Шагж гуайн орчуулсан "Болорын толь"-д
Dad ba rgyal po	Dang pa rgyal po	Dang pa rgyal po
Dharma shwa ra	Dharma swa ra	Dharma swa ra
Skyi ston	Skye ston	Skye ston
Nya dbon	Nya dpon	Nya dpon
Ngam ring	Dam ring	Dam ring
Zhwa lu	Zha lu	Zha lu
Kong gsum pa	Gong gsum pa	Gong gsum pa
Bye rdzing	Byi rjid	Byi rjid
'jam rin pa	'jam rim pa	'jam rim pa

Хоёр. Орчуулгын үгсийн сангийн онцлогоос

1. Оноосон нэрийг орчуулсан нь

Нэг төрлийн юмыг бусад зүйлээс ялгаж тухайлан нэрлэсэн хүний нэр, газар ус, улс хот суурины нэрийг оноосон нэр гэдэг. "Мэргэд гарахын орон толь"-д оноосон нэрийг орчуулах тухайд санскрит төвд гаралтай оноосон нэрийг санскрит буюу төвдөөр нь хуулбарлан, чухам юуны нэр болохыг заан тэмдэглэхийг чухалчилсан байдаг. Тиймээс ч манай уламжлалт орчуулгын зохиол болох "Бодьсатвын явдалд орохуй", "Үлгэрийн далай", "Субашид" зэрэгт оноосон нэрийг энэтхэгээр нь сэргээн буулгасан байна. Тухайлбал "Бодьсатвын явдалд орохуй"-д: Lag bzang (мон.: сайн гар)- Субуража, 'jam dbyangs (мон.: зөөлөн эгшиг)- Манжушри, Kun tu bzang po (мон.: хамгаа сайн)- Самандабадра гэх мэт. Харин эрдэмтэн Шагж гуай оноосон нэрийг хэрхэн орчуулсаныг авч үзвэл:

1. Санскрит хэлнээс төвд хэлнээ орчуулсан оноосон нэрийг мөнхүү төвдөөр нь хуулбарлан буулгажээ. Тухайлбал:

Төвд эхэд	Шагж гуайн орчуулгад	Уламжлалт орчуулгад
Zla grags	Дадаг	Чандракирти
Dbyig gnyen	Егнэн	Васубанду
Phyogs glang	Чоглан	Дигнага
Chos grags	Чойдаг	Дармакирти

2. Оноосон нэрийн тодотголыг хоёр янзаар буулгажээ.

а. Орчуулсан нь:

Үгчилж орчуулбал "мэлмийн өмнө агч", утгаар нь буулгавал "бараа бологч" (spyans nga) гэсэн тодотгол үгийг "мэлмийн нит" гэж орчуулжээ. Жишээ нь:

Мэлмийн нит дэхи Балсанба	(spyans nga dpal bzang ba)
Мэлмийн нит дэхи Гунгаалодой	(spyans nga kun dga' blo gros)
Мэлмийн нит дэхи Лодойжалцан	(spyans nga blo gros rgyal mtshan)
Мэлмийн нит дэхи Намхаажалцан	(spyans nga nam mkha' rgyal mtshan)
Мэлмийн нит дэхи Ринчэнжалцан	(spyans nga rin chen rgyal mtshan)
Мэлмийн нит дэхи Ринчэнпэлба	(spyans nga rin chen 'phel ba)
Мэлмийн нит дэхи Соднамлхүндүв	(spyans nga bsod nams lhun grub)
Мэлмийн нит дэхи Шонну-Од	(spyans nga gzhon nu 'od)

Түүнчлэн "хор", "сог" буюу "монгол" гэсэн тодотголыг орчуулжээ. Тухайлбал:

Монгол багш Намхаабалба	(hor ston nam mkha' dpal ba)
Монгол Балжи-иш	(sog po dpal kyi ye shes)
монгол Лхабал	(sog po lha dpal)

Мөн "гүнчэн", "тамжад чэнба" гэсэн тодотголыг "хамгийг айлдагч" гэж орчуулжээ. Жишээ нь:

Хамгийг айлдагч Жэвзүнба	(kun chen rje btsun pa)
Хамгийг айлдагч Лувсангалсанжамц	(thams cad mkhyen pa blo bzang bskal bzang rgya mtsho)
Хамгийг айлдагч Лувсанжамбалжамц	(thams cad mkhyen pa blo bzang 'jam dbal rgya mtsho)
Хамгийг айлдагч Пагба-Од	(kun mkhen 'phags pa 'od)

Төвдөөр "лочэн" буюу "их орчуулагч" гэсэн тодотголыг "их хэлмэрч" гэж орчуулсан байна. Жишээ нь:

Их хэлмэрч Дармашри	(lo chen dhar ma shri)
Их хэлмэрч Жавчогбалсан	(lo chen skyabs mchog dpal bzang)
Их хэлмэрч Намсан	(lo chen nam bzang)

Төвдөөр "гэвш чэнбо" гэсэн тодотголыг "их буяны садан" гэж орчуулжээ. Жишээ нь:

Их буяны садан Долунба	(dge bshes chen po gro lung pa)
Их буяны садан Хамбалунба	(dge bshes chen po khams pa lung pa)
Их буяны садан Шараба	(dge bshes chen po sha ra ba)

Төвдөөр "жансэм" гэсэн үгийг "бодьсатва" гэж орчуулсан байна. Жишээ нь:

Бодьсатва Гунгаасанбо	(byang sems kun dga' bzang po)
Бодьсатва Даважалцан	byang sems zla ba rgyal mtshan)
Бодьсатва Дэмотанба Лодойжалцан	(byang sems bde mo thang pa blo gros rgyal mtshan)
Бодьсатва Жалцандагсан	(byang sems rgyal mtshan grags bzang)
Бодьсатва Жамбалнинбо	rgyal sras 'jam dpal snying pa)
Бодьсатва Лодойчэнбо	(byang chub sems dpa' blo gros chen po)
Бодьсатва Рүдэнба Шагжасоднам	(byang sems rwa sgreng ba shAkya bsod nams)

Бодьсатва Цүлтимбалсан (byang sems tshul khrims dpal bzang)
 Бодьсатва Шоннужалчог (byang sems gzhon nu rgyal mchog)

б. Зэрэг дэв, цол хэргэмийн тодотголыг орчуулаагүй галиглажээ. Тухайлбал: гэвш(буяны садан), цорж (номын богд), равжамба (маш хэтэрсэн), лобон (сургагч ноён), гавж (арван бэрх), ринбочэ (эрдэнэ), ханчэн (их убадини), жалва (ялгуусан), жалсрай (ялгуусан хөвгүүн), жүдба (тарнич), жүдчэн (их тарнич), жүнийба (арван хоёр), жэ (богд) гэх мэт.

3. Зарим оноосон нэрийн тодотголыг уламжлалт орчуулгын зарчмыг баримталж төвдөөр бус уйгар хэлээр сэргээн орчуулсан байна. Жишээ нь:

Аяга тахимлиг архад Гхалаша (dge slong dgra bcom pa gha la sha)
 Аяга тахимлиг Дэжид (dge slong bde byed)
 Аяга тахимлиг Зивлог (dge slong rtsibs logs)
 Аяга тахимлиг Ловсандарма (dge slong blo bzang dar ma)
 Аяга тахимлиг Сэнгэ (dge slong seng ge)

4. Илт өгүүлэх нэрээр хэлбэржсэн оноосон нэрийг орчуулсан байдлыг ажиглавал санскритаар сэргээн буулгахын хамт тухайн хам сэдвийн утгад дүйлгэн орчуулжээ. Тухайлбал: үл ялагдах гэсэн утгатай "mi rham" гэсэн Майдар бурханы илт өгүүлэх нэрийг орчуулахдаа Майдар бурханы олон илт өгүүлэх нэрээс "итгэл" гэсэн нэрийг сонгон авч, "и" эгшгээр толгой холбон шүлэглэжээ. Тухайлбал:

Ялгуусны зарлигийн нууц сан бүхнийг эзлэн бариад
 Илтгэн тоолшгүй орноо элдэв хувилгаанаар
 Янагуух үнэмлэх номын баярын хуримыг түгээн зохиогч
Итгэл Майдар хийгээд Манзуширт бишрэн мөргөмүү.

2. Нэр томъёог орчуулсан нь

Шагж гуайн орчуулгад диян (bsam gtan), самади (ting nge 'dzin), вишай (yul), вед (rig byed), бодгал (gang zag), авидарма (mngon mdzod), бивангирд (lung), архад (dgra bcom), бярман (bram ze), аяга тахимлиг (dge slong), бодьсатва (byang sems), голди (bye ba), убадини (mkhan po), бинвад (bsod snyoms), махамудра (phyag chen), очирваань (phyag na rdo rje), барамид (phar rhyin), усамбад болох (bsnyen rdzogs), адистид (byin rlabs), егээр (rnal 'byor), йогини (rnal 'byor ma), ширваг (nyan thos), махагал (mgon po) зэрэг олон нэр томъёог монгол орчуулгын уламжлалыг баримталж төвдөөр бус санскритаар нь сэргээн авчээ.

Нөгөөтэйгүүр Шагж гуайн орчуулгад төвд үг цөөнгүй орсон байх бөгөөд зонхилон буддын гүн ухааны холбоотой үг байна. Тухайлбал:

тогтсон тааллын нэр: сэмзамба (sems tsam pa), жэмра (bya smra), додэва (mdo sde ba), талжурва (thal 'gyur ba), ум (dbu ma), ранжүдба (rang rgyud pa), оймрава (dngos smra ba), нинма (snying ma), гаажүдба (bka' rgyud pa), гармаба (kar ma ba), гаадам (bka' gdams), гэдан (dge ldan).

хэргэм зэргийн нэр: агчэн (sngags chen), агчан (sngags 'chang), агшад (sngags bshad), банчэн (pan chen), бонлов (dpon slob), гаашиба (bka' bzhi ba), гавж (dka' bcu), гүнчэн (kun chen), гэвш (dge bshes), жалва (rgyal ba), ловон (slob dpon), ринбочэ (rin po che), ханчэн (mkhan chen), цорж (chos rje), жово (jo bo), жэ (rje), дүвчэн (grub chen) гэх мэт.

"Мэргэд гарахын орон" тольд орчуулсан байдаг буддын шашны тогтсон тааллын нэрийг Шагж гуай төвдөөр нь зээлдэн авчээ. Тухайлбал:

Төвд эхэд	"Мэргэд гарахын орон" тольд	С. Шагж гуайн орчуулгад
Mang bkur ba'i sde	Олноор өргөсөн аймаг	Мангүрвийн аймаг
Grangs can pa	Тоочин	Данжанба
Tshan pa ba	Эсрүатан	Цанбаба

Khyab 'jug pa	Вишнүтэн	Чавжүгба
Dpyod pa ba	Шинжлэгчин	Жодбава
Dbang phyug pa	Махешварчин	Ванчүгба
Bye brag pa	Өвөрмөцчин	Жэврагба
Rig pa can	Ухагчин	Ригбажан
Gcer bu ba	Нүцгэнчин	Жэрбүба
Thal 'gyur ba	Хэтрүүлэгч	Талжүрва
Rang rgyud pa	Өөрийн үндэстэн	Ранжүдба
Gzhi thams cad yod par smra ba	Хамаг орныг буй хэмээн өгүүлэгч	Шитамжадэдбармрава
Ngo bo nyid med par smra ba	Мөн чанар үгүйе өгүүлэгч	Овонидмэдбармрава

Шагж гуай оноосон нэрийг зонхилон галиглан буулгасныг ямар нэг хэмжээгээр тухайн нийгэм цаг үетэй холбоотой гэж бодож байна. Шагж гуайн орчуулга бол 20–р зууны эхэн үеийн орчуулгын нэгэн баримт болох бөгөөд энэ үед Монгол оронд хэдийгээр хувьсгалын дараахан үе буюу 1924 он байсан боловч шашин сүм хийдийн нөлөө хүчтэй хэвээрээ, сүм хийдийн дэргэдэхи буддын шашны сургалт болон монголчуудын төвд хэлнээс ном зохиол орчуулах үйл тасралтгүй үргэлжилсээр байсан үе билээ. Өөрөөр хэлбэл 300 шахам жил монгол оронд төвд хэл эрдэм номын хэл болж байсан үе бөгөөд монгол орчуулагчидын төвд үгийг аль болох цөөн хэрэглэхийг хичээж, тун аргагүй чухал шаардагдсан цөөн тооны төвд үгийг бичгийн хэлэнд зээлдэн авч байсан уламжлалд цаг үеийн эрхээр өөрчлөлт гарч байсан тийм үе билээ⁷. Энэ үе төвд хэлний нөлөө улам их өссөн байсан үе бөгөөд төвд үсгээр үгчилсэн ном зохиол хүртэл гарч, сүм хийдийн хүрээнд шашин гүн ухааны төвд нэр томъёог хэл яриандаа шууд төвдөөр нь зээлдэн хэрэглэж байснаас тэр нь бичгийн хэлэнд хүртэл нөлөөлж байсныг буддын шашны боловсролтон Шагж гуайн орчуулга харуулж байна.

Гурав. Орчуулгын найруулгын онцлогоос

Шагж гуайн үгсийн сан, хэлзүйн хувиргал хийсэн зарим сонин жишээнээс дурдвал *lung gi yon tan 'phags pa che rung/ rtogs pa'i yon tan bla ma rgya pho~rgya bo mtho ba 'dra zhes rgyal pos lkog tu gleng ba* гэсэн өгүүлбэрийг [Хубилай сэцэн хаан] ...түүний урьд Гарма багшид сүслэснээр, эшийн эрдмээр Пагва их байж болмуй, онолын эрдмээр халтар лам минь өндөр нь лав хэмээн далд өгүүлсэн.... гэж орчуулсан байна. Төвд хэлний "rgya bo" гэсэн үг 1–рт халиун халтар 2–рт битүү сахал, сахалт гэсэн утгатай. Хубилай хаан эхэн үедээ Гармын шашны лам нарыг шүтэж байсан бөгөөд Гармын лам нар хар малгай өмсөх учир түүгээр нь "халтар лам" гэж орчуулсан бололтой. Нөгөөтэйгүүр "минь" хэмээх биед хамаатуулах нөхцөлөөр найруулсан нь Хубилай хаан Гармын ламыг дотлолон шүтэж байсан санааг илэрхийлжээ. Мөн төвд эхийн "эшийн эрдэмээр Пагва их" гэснийг "эшийн эрдмээр Пагва их байж болмуй" хэмээн ерийн болох гэсэн үгийн оронд "байж болмуй" гэсэн баймж үйл үгийг нэмсэн нь Хубилай хаан Пагва ламын эрдэм чадалд эхэн үед эргэлзэж байсан санааг оновчтой гаргажээ.

"Шэлжи мэлон" хэмээх зохиол дахи тахил төгсгөлийн шүлэг болон завсрын шүлгийг хэрхэн орчуулсан жишээнээс авч үзвэл:

Rab 'byams grub mtha'i dbye ba kun gzigs nas
Smra ngan grub mtha'i 'dod pa sun phyungs te
Rnam dag grub mtha'i de nyid 'doms mdzad pa
Thub dbang grub mtha'i bdag por phyag tshal lo

Маш хэтэрхий олон тогтсон тааллын ялгал бүхнийг айлдаад
Муу өгүүлэгч тогтсон тааллуудын таалал дуршилыг сөхөөн
Магад ариун тогтсон тааллын тэр чанарыг удвислан зохиогч
Манлай чадагчийн эрхт тогтсон тааллын эзэн түүнээ мөргөмүү

⁷ Ц. Дамдинсүрэн, *Монгол хэлэнд орсон төвд үг*, ОУМХБЭ–ийн анхдугаар хурал, Улаанбаатар, 1961, 63–р тал.

Энэ шүлэгт "м" үсгээр толгой холбон шүлэглэхдээ "магад", "манлай" зэрэг үг нэмсэн, шүлгийн хэмнэлд тааруулан "dod pa" буюу "хүсэл, таалал" гэсэн үгийг "таалал дуршил" гэсэн хоршоо үгээр орчуулжээ. Цаашилбал:

Tshul gnyis 'dab brgya ba dang ku mu ta tshal so sor leg byed pa'i
Nyí zla zung cig 'char zhes rgyal ba rang gis lung bstan ji bzhin du
Gsung rab drang nges legs par phye ste dbu sems shing rta'i srol chen po
Gsal mdzad klu sgrub thogs med ces grags 'jig rten mig gnyis rgyal gyur cig гэсэн шүлгийг

Хоёр дээд ёсны зуун навчит хийгээд гүмүдаан цэцэглэгийг тус тус сайтар ялгагч
Хос наран саран ургамуй хэмээн ялгуусан өөрөө эш үзүүлсэн тэрчилэн
Хотол сайн номлолын удирдах магадыг өөрөө эш үзүүлсэн тэрчилэн
Хотол сайн номлолын удирдах магадыг сайтар ялгаж у сэмийн их тэргэн замыг
Хувьтанаа тодруулан зохиогч Нагаржуна, Түрвэл үгүй хэмээн алдаршсан ертөнцийн
хоёр нүдтэн ялтугай

Энэ шүлэгт "х" үсгээр толгой холбох зорилгоор "хотол", "хувьтан" зэрэг үгийг нэмсэн, "зуун навчит" гэсэн лянхуа цэцгийн илт өгүүлэх нэрийг "Мэргэд гарахын орон толь"—д нуусан нэрээр орчуулахыг заасан ёсоор орчуулсан, "у сэм" буюу умава сэмзам "төв үзэл", "сэтгэл төдийтөн" гэсэн их хөлгөний чиглэлийн нэрийг төвдөөр нь хуулбарлаж буулгасан, харин энэтхэгийн гүн ухаантан Лүдүвийн нэрийг санскритаар Нагаржуна, Тогмэдийг "Түрвэл үгүй" гэж орчуулжээ. Монгол шүлгийн үгийн тоог тэнцүүлэн шүлэглэдэг зарчмыг баримталж, олон үг нэмж орчуулжээ. Тухайлбал төвд шүлгийн 7 үеэр шүлгэлсэн:

Grub mtha' kun dang mnyes gshin pas
Chags sdang rtsod pa yongs bral bar
Gtsug gi rgyan du 'dzin byed pa
De yi byung ba mdo tsam smras гэсэн шүлгийг

Тогтсон таалал бүхэн лүгээ сайхан айлаар
Урин тачаалын тэмцлийг үйлдэхүйгээс огоот хагацаж
Зулайн дээд чимэгт барьж, хүндлэн үйлдэгч
Түүний түүхийг товчийн төдийхнөөр өгүүлвэй би

хэмээн 1-р мөрт "сайхан айл", 2-р мөрт "үйлдэхүй", 3-р мөрт "дээд", "хүндлэн", 4-р мөрт "би" зэрэг үсийг нэмэн, утгыг зөв буулгахын хамт уншихад сонсголонтой хөрвүүлжээ.

Шагж гуай монгол хэлээ чадамгай сайн эзэмшсэн орчуулагч байсныг олон жишээнээс харж болох байна. Төвд хэлний "zug za" гэсэн үгийг үтээрхэл (utugerkel) гэж орчуулсан бөгөөд энэ нь монгол хэлний "атаа" гэсэн үгээс гаралтай, атаархал гэсэн үгтэй ойролцоо утгатай үг. Төвд толь бичигт энэ үгийг "егөөдөл", "егөөдөх", "буруушаан дайрах", Ю.Н. Рерихийн тольд "ирония, сатира, высмеивать, язвить, сердиться, гневаться" гэж тэмдэглэжээ. Норжингийн тольд "үтээрхэх" гэсэн үгийг "бусдаас урвах давах гэж далдуур өрөсч мөрийцөх", Я.Цэвэлийн тольд "атаархах мөчөөрхөх" гэж тайлбарласан байх бөгөөд энэхүү үйл үгээс үүссэн нэр үгийн "үтээрхэл" гэсэн хэлбэрийг Шагж гуай орчуулгадаа сонгожээ. Нөгөөтэйгүүр орчуулгын толь бичгээр тогтоосон үгийн орчуулгад хүлэгдээгүй орчуулгын олон сонин хувилбар түүний орчуулгад тааралдаж байна. Тухайлбал: gshags ral—зарга эвдрэл, ljid che ba—чанар ихтэй (толь бичигт: их хүнд, чамбай), gam thar—цадиг, тууж, gzug gi rgyan—зулайн чимэг (толь бичигт: оройн чимэг) гэх мэт.

Олон орны эрдэмтэдийн хэсэг бөлгөөр орчуулсан боловч бүрэн орчуулаагүй байсан буддын гүн ухааны түүхийн "Шэлжи мэлон" хэмээх томхон зохиолыг монголын эрдэмтэн Шагж гуай бүрэн гүйцэд орчуулахын тулд хэдэнтээ хуулбарлан буулгаж, хэл найруулгыг олонтоо засан найруулсан, уламжлалт орчуулгын зарчмыг зарим үед баримталсан боловч зарим үед түүнээс хазайсан зэрэг нь тухайн эхийн агуулга, хам сэдвийн онцлогт нийцсэн зөв тохиролыг олохын тулд түүний бүтээлч эрэл хайгуул хийж байсныг гэрчлэх баримт болох юм. Шагж гуайн орчуулгыг авч үзэхдээ түүний орчуулгын зөвхөн сүүлчийн сийрүүлэг болох хоёр дэвтэр эхийг үзээд зогсохгүй бусад сийрүүлэг болон анхны нооргийг ч хүртэл анхаармаар юм байна. 16

дэвтэрээс бүрдэх түүний орчуулгын эхүүд Шагж гуайн нөр их хөдөлмөр, хичээл зүтгэлийг илтгэн харуулахаас гадна төвд хэлнээс орчуулга хийх хүмүүст нэрт орчуулагчийн арга туршлага бүтээлч эрэл хайгуулаас суралцахад чухал гарын авалга болох юм. Нөгөөтэйгүүр уг орчуулга бүхэлдээ дундад зууны үеийн Төв Азийн улс орнууд дахи буддын гүн ухааны төвд монгол сурвалж бичгүүдийг харьцуулан судалж буй хүмүүсийн ширээний ном болох учир Шагж гуайн орчуулга өнөө цагт гарсан цорын ганц бүрэн орчуулга болохын тухайд бидэнд их үнэ цэнэтэй юм. Шагж гуайн орчуулгын ач холбогдлыг үнэлж, оросын нэрт дорно дахины судлаач түүхч агсан эрдэмтэн Р. Е. Пубаев "С.Шагжийн... орчуулга нь "монгол бичгийн хэлийг утга зохиолын хэл төдийгүй гүн ухаан, шинжлэх ухааны хэл болохыг батлахад томоохон хувь нэмэр оруулсаны хувьд шинжлэх ухааны ихээхэн ач холбогдолтой"⁸ гэж дүгнэсэн байдаг.

ABSTRACT

The Buddhist and philosophical work, "Crystal Mirror", by the Tibetan scholar, Luvsanchojinyam (1737-1802, consisting of 12 chapters was translated in part into Russian, English, German, and Japanese. The complete translation was done by the Mongolian scholar, S. Shagi, in 1924; the manuscript is preserved in a 16-volume in the Central State Public Library of Mongolia. The article is about Shagi's usage of Gonlun monastery's block-print, and some features of his lexical and writing style.

⁸ Р. Е. Пубаев, *Монгольский перевод С.Шагжи историко-философского сочинения Тугана "хрустальное зеркало"*, Олон улсын монголч эрдэмтний V их хурал, I, Улаанбаатар, 1992, 158-165.